


БАТЛАВ
МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ П. ОДГЭРЭЛ



**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ
“MOCK TRIAL-2023” ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2023.11.10

Улаанбаатар хот

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит “MOCK TRIAL-2023” шүүхийн мэтгэлцээний тэмцээнд хууль зүйн их, дээд сургуулийн оюутан залуус та бүхнийг оролцохыг урьж байна.

Тэмцээний зорилго:

Шүүхийн мэтгэлцээн нь хууль зүйн салбарын оюутнуудыг бодит хэрэг, маргаан дээр хэргийн оролцогчдын байр сууринаас оролцох боломжийг олгох, цаашид хууль зүйн сургуулиудын практик судалгааны үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

Зохион байгуулагч:

Монголын Хуульчдын холбоо

Хамтран зохион байгуулагч:

Хууль зүйн шинжлэх ухаан, Хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо, Шүүгчдийн хороо, Иргэний эрх зүйн хороо, Захиргааны эрх зүйн хороо, Эрүүгийн эрх зүйн хороо, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн анхан шатны шүүх.

Мэтгэлцээний салбар:

Шүүхийн мэтгэлцээний тэмцээн нь /MOCK TRIAL/ Эрүүгийн хэрэг, Иргэний хэрэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр дагнан зохион байгуулагдана.

Мэтгэлцээн явагдах хугацаа ба газар:

Шүүхийн мэтгэлцээнийг 2023 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08:30 цагт Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн шүүхийн нэгдсэн байр, Нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн байранд тус тус зохион байгуулагдана.

Хамрах хүрээ:

Сургууль тус бүрээс Эрүүгийн эрх зүй, Иргэний эрх зүй, Захиргааны эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр нэг баг оролцох бөгөөд баг тус бүр 6 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Багийн гишүүн нь хууль зүйн дээд боловсрол олгох магадлан итгэмжлэгдсэн сургуулийн баклавын зэрэг горилох үндсэн ангийн сургалтад хамрагдаж байгаа оюутан байна.

Тэмцээнд оролцож буй баг нь салбар тус бүр нэг удирдагч багштай байна.

Зохион байгуулах журам:

Багууд мэтгэлцээний дүрэмтэй танилцаж дүрэмд оруудах нэмэлт, өөрчлөлтийн саналаа 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 17:30 цагийн дотор бичгээр болон mocktrialmba@gmail.com цахим шуудангаар ирүүлнэ. Нийт ирүүлсэн саналын 50 хувиас дээш ирсэн саналыг дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна. Заасан хугацаанд саналаа ирүүлээгүй тохиолдолд дүрмийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Мэдүүлэгт доорх зүйлсийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Зохих мэдээллийг бүрэн тусгасан багийн мэдүүлэг
- Оюутны үнэмлэхийн хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Багийн гишүүн бүрийн нэг хувь цээж зураг
- Багийн гишүүд болон удирдагч багшийн холбоо барих мэдээлэл
- Бүртгэлийн хураамж Эрүү, Иргэн, Захиргааны эрх зүйн хэрэг тус бүр 400,000 төгрөгийг Хуульчдын холбооны 5027705095 /ХААН БАНК/ тоот дансанд хийж баримтыг хавсаргана.

Шүүхийн мэтгэлцээний журам:

Шүүхийн мэтгэлцээнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн мэтгэлцээний дүрмийн дагуу явуулна.

Техникийн зөвлөгөөн:

2023 оны 11 сарын 23, 12 дугаар сарын 01-ний өдөр тус тус 14 цагт "Хууль зүйн үндэсний хүрээлэн, 4 давхар, 302 тоот"-д болно.

Эхний зөвлөгөөнөөр дараах үйл ажиллагаа явагдана. Үүнд:

- Дүрэмд орсон өөрчлөлтийг нэгтгэн дүгнэж батлах
- Мандат олгох

Хоёр дахь зөвлөгөөний хурлаар дараах үйл ажиллагаа хийгдэнэ. Үүнд:

- Битүүмжилсэн кейсийг задлах
- Багуудад оноолтын журам танилцуулах

Техникийн зөвлөгөөнд зөвхөн багийн удирдагч багш, ахлагч нар төлөөлөн оролцоно.

Шагнал:

- Салбар эрх зүй тус бүрд:
 - 1 дүгээр байр /1 баг/-Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
 - 2 дугаар байр /1 баг/-Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
- Салбар эрх зүй тус бүрд:
 - Шилдэг илтгэгчийн шагнал /3 илтгэгч/-Өргөмжлөл, дурсгалын зүйл
- Нийлбэр дүнгээр "Аврага баг" /1 баг/-Аваргын цом, дурсгалын зүйл

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-7, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр 4 давхар, 406 тоот.

Холбоо барих дугаар: 70116008, 88047845 /Хууль зүйн шинжлэх ухаан, Хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих хороо хариуцсан мэргэжилтэн Э.Сувд/